МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Г.ӨЛЗИЙБҮРЭН ТАНАА

2013-10-10 № 01/79

Зориулалтын бус зардлыг нөхөн
төлүүлэх тухай

"Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар Төрийн өмчийн хорооны зөвшөөрөлгүй, Хан-Уул дүүргийн Өвөр зайсан дахь "Бугат" ажиллагсдын зуслан барихад 207,669,545 төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.11-д "Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна", 35 дугаар зүйлийн 35.2-д "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна", 37 дугаар зүйлийн 37.1.7-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн "Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн тухай" 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх" гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

2. Улсын төсөвт оруулбал зохих 207,669,545 төгрөгийг Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2013 оны 11 дүгээр сарын 01-ны дотор төвлөрүүлэх;

2. Тогтоосон хугацаанд ажлыг зохион байгуулж, биелэлтийг 2013 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нямдорж нарт хариуцуулав

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын
Аудитор С.Цэцэг-Өлзий

Туслах аудитор Л.Нямтөмөр

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

Газрын тосны газрын дарга
Г.Өлзийбүрэн

Эдийн засаг, санхүү, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга
С.Нямдорж

070288